

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА, САНГИЙН САЙД, ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН
КОРПОРАЦЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 03 дугаар
сарын 01-ны өдөр

Дугаар А-62/63/31/А/26

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27² дугаар зүйлийн 27².5.5, 28 дугаар зүйлийн 28.1.15, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 6.2.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.


2. “Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж, үр дүнг жил бүр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж ажиллахыг Монголбанкны Мөнгөний бодлогын газар (Б.Баярдаваа), Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар (Н.Оюунчимэг), Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар (Ц.Зоригтбат), Хадгаламжийн даатгалын корпорацийн дэд захирал (С.Дамдиндорж)-д тус тус даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА




Д.БАЯРСАЙХАН

САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦЫН
ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



Д.ДУУЛАЛ



Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр

1. Хөтөлбөрийн үндэслэл

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр нь “Алсын хараа 2050”, “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн, дунд хугацаанд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бодлогын арга хэмжээг хүрэх үр дүнтэй уялдуулан тодорхойлсон баримт бичиг болно.

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь аж ахуй нэгж, байгууллагуудын бүтээмжийг дээшлүүлэх, орон нутаг, алслагдсан бүс нутгуудад амьдарч буй иргэд, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, эдийн засгийн оролцоог сайжруулахад бодлогын чухал хэрэгсэл болж байна.

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд шинэ технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, түүнийг таниулах, санхүүгийн олон дэд салбар (жишээ нь банк, бичил санхүү, даатгал гэх мэт), мэдээлэл харилцаа холбооны технологи, өгөгдлийн дэд бүтцийг хамарсан бодлогын өргөн хүрээтэй зорилтыг дэвшүүлж, эрэлт ба нийлүүлэлтийн талыг хамтад нь авч үзэх шаардлага тулгарч байна.

Статистик мэдээллээс харахад манай улсын санхүүгийн үйлчилгээний хүртээмж хөгжлийн ижил түвшинд буй улсуудтай харьцуулахад өндөр гарсан нь арилжааны банкинд данстай иргэдийн тоогоор хэмжиж тодорхойлсон явдал юм. Манай улсад ихэвчлэн арилжааны банкны хадгаламж, зээлийн үйлчилгээгээр үйлчлүүлж хэвшсэн боловч банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоод, хөрөнгийн болон даатгалын зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ бага байна.

Түүнчлэн манай улсын санхүүгийн зах зээл дээрх санхүүжилтийн бүтээгдэхүүний үнэ өндөр, иргэдийн санхүүгийн зах зээл, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг бага, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн онцлогт тохирсон санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж хомс, дэд бүтэц сул хөгжсөн.

“Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх бодлого, зорилт, арга хэмжээний “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох” зорилгын хүрээнд “Санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Иймд “Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр” /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийн төслийг сүүлийн жилүүдэд санхүүгийн хүртээмж нь хурдацтай нэмэгдэж буй улс орнуудын туршлага болон өөрийн улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, бодлогын баримт бичгүүдэд үндэслэн боловсрууллаа. Энэхүү баримт бичгийг боловсруулахад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт талын хүчин зүйлсийг харгалзан үзэж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, боломжуудыг тодорхойлсны үндсэн дээр цаашид авч хэрэгжүүлэх зохистой зохицуулалтын арга хэмжээг боловсруулж төлөвлөсөн.

Монгол Улсын хэмжээн дэх санхүүгийн хүртээмжийг Дэлхийн банкнаас гаргадаг “Global finindex database”-ийг ашиглан хүртээмжийн түвшинг улс орнуудтай харьцуулж, “Эн Ар Си Си” судалгааны байгууллагатай хамтран түүврийн аргаар үндэсний санхүүгийн хүртээмжийн түвшинг үнэлсэн. Үүнд судалгаанд оролцогчдын 95.6 хувь нь банкинд өөрийн нэр дээр хамгийн багадаа нэг данстай бөгөөд 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг. Мөн давхардсан тоогоор иргэдийн 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь ББСБ, 3.4 хувь нь ХЗХ-гоор үйлчлүүлдэг ба МУ-ын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг. Харин 5.2 хувь нь санхүүгийн албан болон албан бус үйлчилгээ ашигладаггүй буюу санхүүгийн үйлчилгээний хүрээний гадна, 0.3 хувь нь албан бус секторт хамрагдаж байна. Хотын иргэдийн 93.4 хувь, орон нутгийн иргэдийн 90.0 хувь нь идэвхтэй данстай.

Санхүүгийн хүртээмж орлогын бүлгээр ялгаатай буюу бага орлоготой бүлгийн 92.6 хувь, хамгийн өндөр орлоготой бүлгийн 97.8 хувь нь албан сектороор үйлчлүүлдэг байна. Түүнчлэн, хамгийн бага орлоготой бүлгийн 87 хувь, хамгийн өндөр орлоготой бүлгийн 97 хувь нь банканд идэвхтэй данстай байна.

2. Хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилго, зорилт

2.1. Санхүүгийн бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонголттойгоор хямд, хялбар, түргэн шуурхай, чирэгдэлгүй хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилго 1. Иргэд нь санхүүгийн боловсролтой, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрхзүйн орчин бүрэлдсэн, хэмжигдэж үнэлэгдэхүйц санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

Зорилт 1.1. Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчин, гомдол барагдуулах механизмыг бий болгон санхүүгийн хэрэглэгчээс гаргасан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой гомдол, маргааныг үе шаттайгаар, чирэгдэл багатай, хурдан шуурхай барагдуулах алтернатив тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 1.2. Иргэд, аж ахуй нэгжүүд өөрсдийн хэрэгцээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглахад санхүүгийн мэдлэгийг зорилтот бүлэг тус бүрээр дээшлүүлнэ.

Зорилт 1.3. Санхүүгийн хүртээмжийг хэмжих мэдээллийн санг үүсгэж, үнэлгээ хийж, олон нийтэд мэдээлж, шийдвэр гаргалтад ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 1.4. Санхүүгийн хэрэглэгчийг өрийн дарамтад оруулахаас сэргийлэх, түүнд тавигдах санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зохистой харьцааны хяналт шалгалт хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоно.

Зорилго 2: Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтын орчныг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, зохистой хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 2.1. Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, харилцагчийг таних болон гарын үсгийн баталгаажуулалтыг цахимжуулна.

Зорилт 2.2. Технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах дэд бүтцийг хөгжүүлнэ.

Зорилт 2.3. Зохицуулагч байгууллагуудад санхүүгийн технологиор мэргэшсэн хянан шалгагч нарыг бэлтгэнэ.

Зорилт 2.4. Санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

Зорилго 3: Бичил санхүүжилт, жижиг дунд үйлдвэрлэл, ногоон санхүүжилтээр дамжуулан банкнаас бусад санхүүгийн зах зээлийн санхүүжилтийн орчныг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.1. Бичил санхүүгийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлж, хямд өртөг бүхий эх үүсвэрээр хангах боломжийг сайжруулж, үйлчилгээний өртөгийг бууруулна.

Зорилт 3.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн эрэлтийг хангах санхүүжилтийн орчныг бүрдүүлнэ.

Зорилт 3.3. Ногоон санхүүжилтийн орчны эрх зүйн орчныг бий болгож, эрсдэлийн удирдлагыг сайжруулна.

Зорилго 4: Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлж, төрөлжүүлэх замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 4.1. Хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй болгоно.

Зорилт 4.2. Даатгалын зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй болгоно.

Зорилт 4.3. Бичил санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 4.4. Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлнэ.

Зорилт 4.5. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж буй санхүүгийн бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ойлгоход хүндрэлгүй буюу бүх мэдээллийг багтаасан, худалдан авахад хялбар, бодитой ил тод байлгах зарчмыг нийтэд нь бүрдүүлнэ.

Зорилт 4.6. Санхүүгийн хүртээмжийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд нэмэгдүүлнэ.

3. Хөтөлбөрийн зорилтот бүлэг, хамрах хүрээ

3.1. Хөтөлбөрийн зорилтот бүлэг нь гарааны бизнес эрхлэгчид, мэргэжлийн оролцогчид, хөдөө орон нутгийн иргэд, залуучууд болон орлого багатай иргэд бөгөөд зорилтот бүлэг тус бүрт хамаарах стратегийн арга хэмжээг тусгасан.

4. Хөтөлбөрийн үр дүн

4.1. Хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. Хууль эрх зүйн орчин боловсронгуй болж, дэвшилтэт технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтэрч, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэж, үйлчилгээний зардал буурна.

4.1.2. Иргэдийн санхүүгийн боловсрол дээшилж, санхүүгийн үйлчилгээг хямд, хялбар, түргэн шуурхай, хүргэх цогц нөхцөл бүрэлдэнэ.

4.1.3. Санхүүгийн хяналт, зохицуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.

4.1.4. Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх үзүүлэлт 2019 оны суурь үзүүлэлтээс 2 дахин нэмэгдэнэ.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүнг шалгуур үзүүлэлтээр дүгнэхдээ 2019 оны үзүүлэлтийг суурь болгоно.

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

5.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

5.1.1. Алсын хараа 2050, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн бодлогын залгамж шинж чанарыг хадгалах;

5.1.2. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах, ил тод байх;

5.1.3. Олон улсын жишигт нийцүүлэн Их 20-ын орнуудын санхүүгийн хүртээмжийн шинжээчдийн бүлгээс гаргасан манлайлал, олон тулгуурт байдал, шинэчлэл, эрх мэдэл, эрх ашгийг хамгаалах, хамтын ажиллагаа, мэдлэг, тэнцвэртэй байдал, тогтолцоо гэсэн 9 зарчмыг баримтлах.

6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

6.1.1. улсын төсөв;

6.1.2. олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж;

6.1.3. хувийн хэвшил болон бусад эх үүсвэр.

7. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг 2020-2025 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

Нэгдүгээр үе шат 2021-2023 он

Хоёрдугаар үе шат 2023-2025 он

7.2. Хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хороо удирдан хэрэгжүүлнэ.

7.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгэм, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорац хариуцна.

7.5. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн оролцогч талууд дараах үүрэгтэй оролцоно:

Оролцогч талууд	СХСХ хөгжүүлэлт дэх үүрэг оролцоо			СХСХ -ын бодлого дах үүрэг оролцоо			
	Тэргүүлэх	Боловсруулах	Зөвлөх	Зорилго 1	Зорилго 2	Зорилго 3	Зорилго 4
Монголбанк	*			*	*		
Санхүүгийн зохицуулах хороо	*			*	*	*	*
Сангийн яам	*			*	*	*	*
Хадгаламжийн даатгалын корпорац	*			*			
Салбарын мэргэжлийн холбоод			*	*	*	*	*
Боловсрол, шинжлэх ухааны яам				*			
Үндэсний статистикийн хороо			*				
Дэд бүтцийн байгууллагууд		*		*	*		
ХХААХҮЯ, ЖДҮДС		*		*			
Олон улсын байгууллага			*	*			

8. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал

8.1. Монголбанк, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорац нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутам Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

8.2. Санхүүгийн зохицуулах хороо хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр нэгдсэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, үнэлгээний дүнг жил бүрийн I улиралд багтаан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулна.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

----- оОо -----



Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн А.12.6.3/31/А/26 дугаар хамтарсан тушаалын хавсралт /"Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр"-ийн хавсралт/

ТУ32072 9020030255

"МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР"-ИЙН

2021-2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дл	Хөтөлбөрийн зорилго, үндэслэл, зорилго	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Тухайн арга хэмжээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (100, чанар, хугацаа) -ийн хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Сүүрх түвшин /2019 он/	Хүрэх түвшин	Хариуцах байгууллага
Зорилго 1: Иргэд нь санхүүгийн боловсролтой, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчин бүрдсэн, хэмжигдэж үнэгдэхүйц санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.								
1.1	Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах, гомдол маргааныг шийдвэрлэх	Өргөдөл гомдлын судалгаанд дүн шинжилгээ хийх, барагдуулах механизм болон системтэйгээр шийдвэрлэх арга замыг бий болгох	2021 - 2022	Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг алдагдуулж буй нийтлэг жишиг, баримтуудыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг боловсруулж, Өргөдөл гомдол хүлээн авах, барагдуулах журам баталж, хэрэгжүүлнэ.	Нэг өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх дундаж хугацаа	22 хоног	18 хоног	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
1.2	Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах, гомдол маргааныг шийдвэрлэх	Санхүүгийн үйлчилгээнд харааг бус омбудсмен харилцагч, оруулагчдын барагдуулах	2021-2025	Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналтын нэгж байгуулагдсан байна.	Нэг өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх дундаж хугацаа	22 хоног	18 хоног	Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
1.3	Санхүүгийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангуулж ажиллуулах	Санхүүгийн байгууллагуудын	2021 - 2025	Санхүүгийн байгууллагуудын санхүүгийн ба үйл ажиллагааны тайланг байгуулага өөрийн цахим хуудсанд байршуулах ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Цахим хуудсанд санхүүгийн тайлан байршуулсан зохицуулалттай этгээдүүдийн нийт дүнд эзлэх хувь	60%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк

1.4	Санхүүгийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох бүх талуудтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх	2021 - 2023	Талуудтай санамж бичиг байгуулж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд тогтмол мэдээлэл солилцдог болсон байна.	Мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлсэн байдлын хэрэгжилтийн хувь	70%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам Хадгаламжийн даатгалын корпорац
1.5	Санхүүгийн байгууллагуудын санхүүгийн ёс зүйн хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авах	2021 - 2025	Санхүүгийн байгууллагуудыг комплаенс хариуцсан ажилтантай болгох, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.	Нийт зохицуулалттай этгээдэд комплаенсыг хэрэгжүүлж буй байгууллагууд	0.5%	34%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
1.6	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэглэгчийн эрхийг хамгаалах мэдээлэл түгээх	2021 - 2025	Холбогдох мэдээлэл, хичээл, сургалтыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан хүргэсэн байна.	Жил бүр 2-оос доошгүй хичээл, сургалтыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан хүргэсэн байх	50%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Хадгаламжийн даатгалын корпорац
1.7	Олон нийтийн санхүүгийн боловсролын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, судалгаа хийх	2021 - 2025	Судалгааг гүйцэтгэх ба судалгааны үр дүн сайжирсан байна.	Үнэлгээний үр дүнг гаргасан байна.	1 удаа	1 удаа	Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо Хадгаламжийн даатгалын корпорац
1.8	Мэргэжлийн оролцогчид, санхүүгийн байгууллагуудтай олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд хамтран ажиллах	2021 - 2025	Мэргэжлийн оролцогчид олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх цахим болон биет сургалт хийж, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар зөвлөгөө хүргэсэн байна.	Санхүүгийн боловсрол олгох чиглэлд хамтран ажиллаж буй зохицуулалттай этгээдүүдийн нийт дүнд эзлэх хувь	0%	31%	Санхүүгийн зохицуулах хороо
1.9	Санхүүгийн хэрэглэгчийн түвшин тус бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн боловсролын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	2021-2022	Хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Монголбанк Сангийн яам Санхүүгийн зохицуулах хороо Хадгаламжийн даатгалын корпорац

1.10	Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд санхүүгийн луйвраас сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах иргэдийг залилан, урьдчилан чиглэлээр гаргаж хэрэгжүүлэх	2021-2025	Иргэд санхүүгийн залилан, луйвраас өөрийгөө хамгаалах мэдлэг, боловсролыг олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Эдийн засгийн гэмт хэргийн тоо	247	222	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
1.11	Гарааны бизнес эрхлэгчид болон залуу хөрөнгө оруулагчдад санхүүгийн боловсрол олгох	Гарааны бизнес эрхлэгчид болон залуу хөрөнгө оруулагчдад санхүүгийн боловсрол олгох	2021 - 2025	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох цахим хуудсыг ажиллуулж, тогтмол мэдээлэл хүргэн, сургалт явуулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0	100%	Санхүүгийн зохицуулах хороо
1.12	Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох	Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох	2022 - 2025	Орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан байна.	Сургалтад хамрагдсан зорилтот бүлгийн тоо, жилээр	220	23160	Санхүүгийн зохицуулах хороо Хадгаламжийн даатгалын корпорац
1.13	Залуу үеийнхэд санхүүгийн боловсрол олгох			Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгосон байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо
1.14			2021-2025	Гарын авлага, товхимол, сургалтын болон танин мэдэхүйн зориулалттай видео, шторк, подкаст, нийтлэл боловсруулж, хэвлүүлэн нийтийн хүртээл болгосон байна.				Санхүүгийн зохицуулах хороо
1.15			2021-2025	Төрийн бус байгууллагатай хамтран сургагч багш нарыг бэлтгэсэн байна.				Санхүүгийн зохицуулах хороо
1.16	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх олон нийтийн мэдлэг, боловсролыг сайжруулах, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон нийтийн мэдлэг, боловсролыг сайжруулах, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	2021-2025	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон нийтэд боловсрол олгосон байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0	100%	Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо
1.17	Санхүүгийн хүртээмжийг хэмжих	Санхүүгийн хүртээмжийн мэдээллийн сан үүсгэх	2021	Санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтийг тодорхойлох, тооцох, цуглуулах гарын авлага гаргасан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	1 удаа	1 удаа	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Хадгаламжийн даатгалын корпорац

1.18		2022	Санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтийг тайлагнах журмыг боловсруулж, тайлангийн маягтыг нэвтрүүлсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	1 удаа	1 удаа	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
1.19		2023 - 2025	Санхүүгийн хүртээмжийн тоон болон чанарын мэдээллийн сан үүсгэсэн байна.	Санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтийг тайлагнах журмын дагуу мэдээллийн сан бүрэн үүссэн байна.	10%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам
1.20	Санхүүгийн хүртээмжийн тойм, тайланг олон нийтэд түгээх	2023 - 2025	Санхүүгийн хүртээмжийн тоймыг гаргасан байна.	Жил бүрийн хэвлэмэл тоймын дугаарын тоо, улирлаар	0	4 удаа	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Хадгаламжийн даатгалын корпорац
Зорилго 2: Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтын орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, зохистой хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хүртээмжийн нэмэгдүүлэх.							
2.1	Санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нутагшуулах холбогдох зохицуулалтыг хийх	2021	Санхүүгийн технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нутагшуулах хүрээнд уян хатан зохицуулалтын орчинг нэвтрүүлсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам
2.2	Санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн эрсдэлд нутагшуулах холбогдох зохицуулалтыг хийх	2021-2025	Даатгалын гэрээг цахимаар болон аливаа дэвшилтэд техник, технологи ашиглан байгуулахтай холбогдох зохицуулалтыг бий болгосон байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо
2.3	Хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх	2022	Санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тайлагналын системийг бий болгох	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
2.4		2022 - 2023	Технологид суурилсан улс дамнасан мөнгөн гуйвуулгын эрхзүйн орчинг сайжруулах	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
2.5	Цахим гэмт хэрэг, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх механизмдыг бий болгох	2022 -2023	Холбогдох дүрэм журмыг батлуулж, эрсдэлийн үнэлгээний програм хангамжийг нэвтрүүлсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам

2.6	Харилцагчийг таньж мэдэх үйлчилгээг цахимжуулах, цахим гарын үсэг нэвтрүүлэхтэй холбогдох журмыг боловсруулж, иргэний бүртгэлийн ХУР системээс санхүүгийн байгууллагууд мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн байна.	2022	Харилцагчийг таньж мэдэх үйлчилгээг цахимжуулах, цахим гарын үсэг нэвтрүүлэхтэй холбогдох журмыг боловсруулж, иргэний бүртгэлийн ХУР системээс санхүүгийн байгууллагууд мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн байна.	Харилцагчийг таньж мэдэх үйлчилгээг цахимаар, цахим гарын үсэг ашиглаж буй зохицуулалттай этгээдийн нийт дүнд эзлэх хувь	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам
2.7	Технологид суурилсан үл хөдлөх хөрөнгийг худалдах, худалдан авах, түрээслэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх	2022	Зохицуулалтын орчинг бүрдүүлж, холбогдох дүрэм журмыг батлуулж, програм хангамжийн хяналтын систем, механизмыг бий болгосон байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам Хууль зүйн яам
2.8	Виртуал хөрөнгөтэй холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх	2021-2024	Виртуал хөрөнгийн хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ	0%	100%	Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
2.9	Технологид суурилсан үнэт цаас, валлот арилжааны цогц платформын нэвтрүүлэх	2022	Хөрөнгийн зах зээлийн арилжааны хэмжээ нэмэгдсэн байна.	Арилжааны хөрвөх чадварын хэмжээ	5%	20%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
2.10	Хамтын санхүүжилтийг /equity crowdfunding/-ийг бий болгох дэд бүтцийг хөгжүүлнэ.	2022 - 2024	Хамтын санхүүжилтийн платформ үүссэн байна.	Хамтын санхүүжилтийн платформоор дамжуулан хөрөнгө оруулалт татсан байна.	0.00 %	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
2.11	Бичил санхүүгийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох цахим тогтолцоог бий болгох	2021 - 2025	Нэгдсэн мэдээллийн сантай болсон байна.	Гүйцэтгэлээр	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо
2.12	Алслагдсан аймгийн төв болон сумдад үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад хөнгөлөлт үзүүлэх	2021 - 2025	Бодлогоор дэмжиж журамд өөрчлөлт оруулсан байна.	Гүйцэтгэлээр	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо

2.13	Боловсон хүчинг бэлтгэх	Зохицуулагч байгууллагуудад санхүүгийн мэргэшсэн боловсон хүчинг бэлтгэх	2021 - 2023	Сүлжээний шалгагч, инженер, дүрэм, журам боловсруулдаг албан хаагч нарыг бэлтгэх хүрээнд холбогдох сургалт, хөтөлбөрт хамруулж эхлэсэн байна.	хянан журам	Зохицуулалтын байгууллагын нийт хянан шалгагчид эзлэх хувь	0%	15%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
2.14	Хамтын ажиллагааг идэвхижүүлэх	Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, мобайл сүлжээний операторууд, санхүүгийн компаниуд технологийн харилцан хоорондын ажиллах боломжийг нэмэгдүүлэх	2021-2025	Талуудтай хамтарсан уулзалт хэлэлцүүлгийг жил бүр өрнүүлж, нэгдсэн шийдэлд хүрнэ	уулзалт	Давтамж	0	5	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
Зорилго 3: Бичил санхүүжилт, жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилт, ногоон санхүүжилтээр дамжуулан банкнаас бусад санхүүгийн зах зээлийн санхүүжилтийн орчинг сайжруулах, хүргэмжийг нэмэгдүүлэх.									
3.1	Бичил санхүүжилт	Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ.	2021 - 2025	Бичил санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа сайжирч, хэрэглэгчийн мэдээлэлд нарийвчилсан үнэлгээ хийдэг тогтолцоо бүрдсэн байна.	санхүүгийн эрсдэлийн	Шаардлага хангасан зохицуулалттай этгээдүүдийн нийт дүнд эзлэх хувь	50%	75%	Санхүүгийн зохицуулах хороо
3.2		Хөдөө орон нутаг дахь гарааны бизнес эрхлэгчдийг дэмжсэн зээлийг бичил санхүүгийн байгууллагаар олгох	2021 - 2025	Хөдөө орон нутаг дахь гарааны бизнест зориулсан зээлийг бичил санхүүгийн байгууллагаар олгож эхлэх боломжоор хангасан байна.	бизнест зээлийн бичил санхүүгийн байгууллагуудын нийт олгосон зээлд эзлэх хувь	Гарааны бизнест олгосон зээлийн бичил санхүүгийн байгууллагуудын нийт олгосон зээлд эзлэх хувь	0%	20%	Санхүүгийн зохицуулах хороо
3.3		Бичил санхүүжилтийн зардлыг бууруулж, зээлийн хүүг бууруулах	2021 - 2025	Бичил санхүүгийн байгууллагуудад зээлдэгч хугацаандаа зээлээ бүрэн эргэн төлж зээлийн сайн түүх үүсгэнээр дахин зээл авахад хүү буурах хөшүүрэг ашиглах, бичил санхүүгийн байгууллагын асаглалын тогтолцоо тогтолцоог сайжруулна.	хүүгийн түвшин /сарын/	Зээлийн хүүгийн түвшин /сарын/	3%	2.2%	Санхүүгийн зохицуулах хороо
3.4		Хэрэглэгчийн дижитал мэдээллийн цар хүрээг сайжруулан зээлийн түүх болон зээл авах чадварыг нэмэгдүүлэх	2021-2022	Хур, Дан, e-mongolia зэрэг төрийн нэгдсэн цахим мэдээллээс зээлдэгчийн талаарх мэдээллийг нэгдсэн байдлаар авах боломжийг бүрдүүлнэ.	Зээлийн хүүгийн түвшин /сарын/	Зээлийн хүүгийн түвшин /сарын/	3%	2.2%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам

3.5	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилт	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилт	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилт	2021-2025	Бичил болон жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн баталгааны хөтөлбөрт нэмэгдүүлж, тэдгээрт зориулсан зээлийн шугам нээх, хөрөнгө оруулалтын сан байгуулагдах бодлогыг хэрэгжүүлнэ.	ЖДҮ эрхлэгчдийн зах санхүүгийн зээлээс санхүүжилт татсан хөрөнгийн нийт санхүүжилтэд эзлэх хувь	50%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
3.6	Санхүүжилт олгох дэд бүтцийг хөгжүүлэн мэдээллийн тэгш бус байдлыг арилган, зээлийн эрсдэлийг бууруулах	Санхүүжилт олгох дэд бүтцийг хөгжүүлэн тэгш бус байдлыг арилган, зээлийн эрсдэлийг бууруулах	Санхүүжилт олгох дэд бүтцийг хөгжүүлэн тэгш бус байдлыг арилган, зээлийн эрсдэлийг бууруулах	2021 - 2025	Хөгжлийн эхэн үедээ буй компаниудын санхүүгийн тайлагнал, засаглалыг сайжруулахад мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж, тэдгээрийн зээлжих зэрэглэлийн тогтолцоог бүрдүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.	ЖДҮ эрхлэгчдэд зээлжих зэрэглэл хийдэг санхүүгийн байгууллагуудын нийт байгууллагад эзлэх хувь	0%	Санхүүгийн зохицуулах хороо
3.7	Зохицуулалттай салбаруудын санхүүгийн тайлангийн маягтад ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, мөрдүүлэх	Зохицуулалттай салбаруудын санхүүгийн тайлангийн маягтад ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, мөрдүүлэх	Зохицуулалттай салбаруудын санхүүгийн тайлангийн маягтад ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, мөрдүүлэх	2021 - 2025	Ногоон санхүүгийн хөрөнгийн ангилалыг бий болгож, холбогдох өөрчлөлтийг тайлангийн системд нэвтрүүлэн, дүрэм журмуудад өөрчлөлтийг оруулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	Санхүүгийн зохицуулах хороо
3.8	Ногоон эдийн засгийг дэмжих хүрээнд гадны болон дотоодын хөрөнгө оруулагчдад нээлтэй экосистемийг бүрдүүлэх	Ногоон эдийн засгийг дэмжих хүрээнд гадны болон дотоодын хөрөнгө оруулагчдад нээлтэй экосистемийг бүрдүүлэх	Ногоон эдийн засгийг дэмжих хүрээнд гадны болон дотоодын хөрөнгө оруулагчдад нээлтэй экосистемийг бүрдүүлэх	2022	Ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбогдох нээлттэй мэдээллийн санг бий болгож, ногоон эх үүсвэр татагчдын зэрэглэлийг тогтоох аргачлалыг боловсруулсан байна. Ногоон зээлийн тайланг тогтмол гаргаж хэвшсэн байна.	Ногоон зээлийн гаргах, тайлан улирлаар	4	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
3.9	Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний зардлыг бууруулах	Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний зардлыг бууруулах	Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний зардлыг бууруулах	2022 - 2023	Ногоон зээл, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний зардлыг бууруулах хүрээнд холбогдох дүрэм, журмыг боловсруулж батлуулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
3.10	Ногоон санхүүжилтийг дэмжих хүрээнд тус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес санхүүгийн эрхлэгчдийг дэмжих	Ногоон санхүүжилтийг дэмжих хүрээнд тус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес санхүүгийн эрхлэгчдийг дэмжих	Ногоон санхүүжилтийг дэмжих хүрээнд тус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес санхүүгийн эрхлэгчдийг дэмжих	2021 - 2025	Ногоон бизнес эрхлэгчдийн зээлийг нэмэгдүүлж, зээлийн нөхцөлийг уян хатан болгоход холбогдох дүрэм, журмыг боловсруулж батлуулсан байна.	ЖДҮ-ийн ногоон зээлийн салбарын нийт зээлд эзлэх хувь	0.39 %	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк

3.11	Ногоон бондын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх	2021 - 2022	Бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын зарцуулалт, үйл явцын үнэлгээ, эрсдэлийн удирдлага, тайлагналтай холбоотой холбогдох дүрэм, журмыг боловсруулж батлуулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам
3.12	Бичил ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх	2021 - 2022	Ногоон зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, эрсдэлийн удирдлага, тайлагналтай холбоотой өөрчлөлтүүдийг оруулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
3.13	Ногоон санхүүжилтийн чиглэлээр хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх	2021 - 2025	Санхүүгийн байгууллагуудын ногоон эдийн засгийн ач холбогдолын талаарх ойлголт, ухамсарыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
3.14	Ногоон, тогтвортой санхүүжилтийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, ач холбогдлыг таниулах	2022 - 2025	Цахим хуудас, нийгмийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл тогтмол хүргэдэг тогтолцоо бүрдсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк
3.15	Банк, санхүүгийн байгууллагын салбарын Ногоон зээлийн статистик мэдээлэлтэй болох	2021-2025	Банк, санхүүгийн байгууллагуудаас ногоон зээлийн мэдээлэл цуглуулахаар холбогдох журмыг шинэчлэн, мэдээллийн бан бүрдүүлсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо
Зорилго 4: Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.							
4.1	Хөрөнгийн зах зээл	Институционал хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлж, идэвхижүүлэх	2021 - 2024	Институционал хөрөнгө оруулагчдийг нэмэгдүүлэх хүрээнд томоохон ААН-үүдэд эх үүсвэрээ хөрөнгийн зах зээлээс татах шаарлагыг холбогдох хуульд тусгуулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.2		Арилжааны хэлцлийн зардлыг бууруулах, арилжаа хийгдэх шат дамжлагыг багасгах	2021 - 2022	Холбогдох дүрэм, журамд өөрчлөлтийг оруулсан байна.	Арилжааны хэлцлийн зардлын нийт арилжаанд эзлэх хувь	2%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.3	Даатгалын зах зээл	Уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын бүтээгдэхүүнийг судалж, бий болгох	2021-2025	Уур амьсгалын болон гамшгийн эрсдэлийн даатгалын хөгжүүлсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	50%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам

4.4	Даатгалын бүтээгдэхүүний хүргэлтийн сүвгийг өргөжүүлэх хүрээнд технологийн суурилсан даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх	2021 - 2025	Даатгалын гэрээг цахимаар болон аливаа дэвшилтэд техник, технологи ашиглан байгуулахтай холбогдох зохицуулалтыг бий болгосон байна.	Технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүний нийт даатгалын бүтээгдэхүүнд эзлэх хувь	0%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.5	Албан журмын даатгалын төрлийг олшруулах талаар судалж, хөгжүүлэх	2021-2025	Барилга угсралт, ашиглалтын үед гарч болзошгүй эрсдэлүүдийг судалж, тус эрсдэлүүдээс хамгаалагдах бүхий албан журмын даатгалыг бий болгож, зах зээлд нэвтрүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	50% 100%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.6	Дижитал санхүүгээр дамжуулан хөдөө орон нутгийн хэрэглэгчид болон хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн шинэ Бичил санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх	2021 - 2025	Технологид суурилсан бичил санхүүгийн үйлчилгээ хүртэж буй хөдөө орон нутгийн иргэдийн тоог 50 хувиар нэмэгдүүлсэн байна.	Гар утсаараа санхүүгийн үйлчилгээ авч буй иргэдийн нийт оролцогсод эзлэх хувь	50% 80%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.7	Бичил санхүүгийн зах зээл	2021	Зээлийн батлан даатгалын сангийн үйлчилгээнд хамрагдах ХЗХ-ын тоог нэмэгдүүлсэн байна.	Зээлийн батлан даатгалын үйлчилгээнд хамрагдсан ХЗХ-ын нийт ХЗХ-д эзлэх хувь	0% 5%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.8	Гар утсаар хийгдэж буй шилжүүлэг, төлбөр тооцооны хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох	2022	Эрх зүйн орчинг боловсронгуй болгож, гүйлгээний тоог 20 хувиар нэмэгдүүлсэн байна.	Гар утсаар хийгдэж буй шилжүүлэг, төлбөр тооцооны гүйлгээний тоо	0% 20%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.9	Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх	2021 - 2025	Төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран холбогдох арга хэмжээг өрнүүлсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0% 100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам
4.10	Хөтөлбөр боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг хангана.	2021 - 2025	Хөтөлбөр боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг хангана.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0% 100%	Санхүүгийн зохицуулах хороо Монголбанк Сангийн яам

	мэдлэг дээшлүүлэх боловсруулж хэрэгжүүлэх	мэргэжлийг төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх							
4.11	Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлнэ.	2021 - 2025	Хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэнэ.	Гэрээний хэрэгжилтийг жил бүр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо		
4.12	Мэргэжлийн холбоодын үүрэг оролцоо, үйл ажиллагааг бэхжүүлнэ	2021 - 2025	Хорооноос мэргэжлийн холбоодын чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам		
4.13	Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж буй санхүүгийн бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ойлгоход хүндрэлгүй буюу бүх мэдээллийг багтаасан, худалдан авахад хялбар, болитой ил тод байлгах зарчмыг бүрдүүлэхэд судалгаа хийх	2021-2022	Холбогдох судалгаа хийгдэж, санал дүгнэлт гарсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Монгол банк Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам		
4.14	Холбогдох хууль, журамд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний ил тод байдлыг хангах зохицуулалтыг тусгаж, хэрэгжилтийг хангуулах	2023-2025	Судалгааны санал, дүгнэлт холбогдох хууль, журамд тусгагдаж, хэрэгжсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Монгол банк Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам		
4.15	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагуудыг холбогдох хууль тогтоомжид тусгахдаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжих арга хэмжээг авах	2021-2025	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагуудыг холбогдох хууль тогтоомжид тусгахдаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Монгол банк Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам		

4.16	Үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаатай холбогдон үүссэн харилцааг зохицуулсан хууль, дүрэм, журмын төслийг боловсруулах, МУТСТ-гэй холбоотой харилцааг тусгах	2021-2025	Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.17	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаатай холбогдон үүссэн харилцааг зохицуулсан хууль, дүрэм, журмын төслийг боловсруулах, МУТСТ-гэй холбоотой харилцааг тусгах	2021-2025	Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яам
4.18	МУТСТ чиглэлээр Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх, аргачлалыг боловсруулах	2021-2023	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд бүрэн шилжсэн байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо
4.19	МУТСТ тухай хуулийн 4.1.2-4.1.7-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар олон улсын сайн туршлагыг судалж, журамд холбогдох өөрчлөлтийг тусгана.	2021-2025	Мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар судалж, журамд холбогдох өөрчлөлтийг тусгаж, сургалт зохион байгуулсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо
4.20	Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газраас даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагуудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийх зайны болон газар дээрх хяналт	2021-2022	Журам шинэчлэн боловсруулагдсан байна.	Гүйцэтгэлээр үнэлнэ.	0%	100%	Санхүүгийн зохицуулах хороо

[illegible]

—○○—